

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн
А/383 дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмыг батлан хамгаалах салбарт ажиллагсдын ажлын амжилт, үр дүн, бүтээлч ажиллагааг урамшуулан дэмжих зорилгоор “Төрийн албаны тухай” хуулийн 51, 52 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн боловсруулав.

1.2. Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, гавьяа байгуулсан, ажлын амжилт гаргасан, цэргийн албыг олон жил үр бүтээлтэй хаасан цэргийн алба хаагч, ажилтанд шагнал, урамшуулал олгоно.

1.3. Яам, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжид ажиллагсдыг тухайн байгууллагын, Зэвсэгт хүчинд ажиллагсдыг Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын саналыг үндэслэн Батлан хамгаалахын сайдын тушаалаар шагнана.

Хоёр. Шагнал, урамшууллын төрөл

- “Эх орны төлөө” батлан хамгаалахын дээд шагнал;
- Батлан хамгаалах яамны “Хүндэт тэмдэг”;
- “Батлан хамгаалахын тэргүүний ажилтан цол, тэмдэг”;
- Батлан хамгаалах яамны “Хүндэт жуух бичиг”;
- “Дайчин алдар I” медаль;
- “Дайчин алдар II” медаль;
- “Дайчин алдар III” медаль;
- “Ахмад дайчин” медаль;
- “Эх орны төлөө I” хүндэт тэмдэг;
- “Эх орны төлөө II” хүндэт тэмдэг;
- “Эх орны төлөө III” хүндэт тэмдэг;
- “Цэргийн хамтын ажиллагааны төлөө” хүндэт тэмдэг;
- Ажиллагааны онцлогийг тусгасан дурсгалын медаль;
- Үнэ бүхий зүйл.

Гурав. Шагнал, урамшуулал олгоход баримтлах үзүүлэлт

3.1. “Эх орны төлөө” батлан хамгаалахын дээд шагналаар үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалахын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой гавьяа байгуулсан цэргийн алба хаагч эсвэл иргэнийг жилд нэг удаа шалгаруулан өргөмжлөл, болор цом, цул мөнгөөр хийгдсэн энгэрийн тэмдэг, 10000000 /арван сая/ төгрөгийг дагалдуулан олгоно.

3.2. Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд оруулсан гавьяа зүтгэл, хувь нэмэр, ажлын үр дүн, амжилтыг нь үнэлж дараах шагналуудаар шагнана.

3.2.1. Батлан хамгаалах яамны “Хүндэт тэмдэг”-ээр Монгол цэргийн өдрийг тохиолдуулан цэргийн албыг 25-аас дээш жил хаасан 5 хүртэлх алба хаагчийг шагнаж, үнэмлэх, 200000 /хоёр зуун мянга/ төгрөгийг дагалдуулан олгоно.

3.2.2. “Батлан хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдгээр цэргийн албыг 20-оос дээш жил хаасан 10 хүртэлх алба хаагчийг шагнаж, үнэмлэх, 100000 /нэг зуун мянга/ төгрөгийг дагалдуулан олгоно.

3.2.3. Батлан хамгаалах яамны “Хүндэт жуух бичиг”-ээр батлан хамгаалах салбарт 15-аас дээш жил ажиллаж байгаа цэргийн алба хаагч, ажилтан нарыг шагнаж, 50000 (тавин мянга) төгрөгийг дагалдуулан олгоно.

3.2.4. Энэ журмын 3.2.1, 3.2.2, 3.2.3-т заасан шагналын дагалдах мөнгийг тухайн алба хаагчийг шагнуулахаар нэрийг нь дэвшүүлсэн байгууллага хариуцна.

3.2.5. “Дайчин алдар I” медалиар 20, “Дайчин алдар II” медалиар 15, “Дайчин алдар III” медалиар 10-аас дээш жил цэргийн алба хаасан алба хаагчийг тус тус шагнаж, үнэмлэх олгоно.

Дайчин алдар медалиар зөвхөн Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийг шагнаж, урамшуулах ба медалийн зэргийн дарааллыг баримтлан шагнана. Шагнал хоорондын хугацаа 5-аас доошгүй жил байна.

3.2.6. “Эх орны төлөө I” хүндэт тэмдгээр 15, “Эх орны төлөө II” хүндэт тэмдгээр 10, “Эх орны төлөө III” хүндэт тэмдгээр 5-аас дээш жил батлан хамгаалах салбарт ажилласан цэргийн алба хаагч, ажилтныг тус тус шагнаж, үнэмлэх олгоно.

Эх орны төлөө хүндэт тэмдгээр үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг шагнаж болно. Хүндэт тэмдгийг зэргийн дарааллыг баримтлан шагнах ба шагнал хоорондын хугацаа 3-аас доошгүй жил байна.

3.2.7. “Ахмад дайчин” медалиар цэргийн албанд 25 ба түүнээс дээш жил ажилласан бэлтгэл, чөлөөнд байгаа генерал, офицер, ахлагч нарыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв болон Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын харьяа ахмадын хорооны саналыг үндэслэн шагнаж, үнэмлэх олгоно.

3.3. Батлан хамгаалахын оны тэргүүний офицер, ахлагч, ажилтныг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан “Батлан хамгаалахын оны тэргүүний ажилтан шалгаруулах журам”-ыг үндэслэн офицер, ахлагч, ажилтан тус бүр нэгийг шалгаруулж, “Өргөмжлөл”, 1000000 (нэг сая) төгрөгөөр шагнана.

3.4. Гадаад, дотоодын амралт, аялал жуулчлалын эрхийн бичгээр хариуцсан албан тушаалын ажил үүргээ үлгэр жишээчээр биелүүлж, батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа цэргийн алба хаагч, ажилтныг шагнаж болно.

3.5. Хариуцсан албан тушаалын болон оногдсон ажил үүргээ идэвх зүтгэлтэй, сайн гүйцэтгэсэн цэргийн алба хаагч, ажилтныг үнэ бүхий зүйлээр урамшуулж, “Дурсамж” хадгалуулна.

3.5.1. Батлан хамгаалах салбарт тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажилласан төрийн албан хаагчийг насны ой, тэмдэглэлт бусад үйл явдлыг тохиолдуулан урамшуулж болно.

3.6. Хоёр орны цэргийн хамтын ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь үнэлж гадаадын цэргийн алба хаагч, дипломат ажилтныг “Цэргийн хамтын ажиллагааны төлөө” хүндэт тэмдгээр шагнаж болно.

3.7. НҮБ-ын мандаттай болон олон улсын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнийг тухайн улс орны болон ажиллагааны онцлогийг тусгасан дурсгалын медалийг бий болгон шагнаж болно.

Дөрөв. Шагнал, урамшуулалд тодорхойлох, уламжлах,
өргөн мэдүүлэх, шийдвэрлэх

4.1. Монгол Улсын цол хүртээх, төрийн дээд одон медаль болон салбарын шагналаар шагнуулах цэргийн алба хаагч, ажилтны тодорхойлолт, холбогдох материалыг тухайн байгууллагын хүний нөөцийн нэгж бүрдүүлж, дээд шатны байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид уламжилна.

4.2. Монгол Улсын цол хүртээх, төрийн дээд одон медалиар шагнуулах бие бүрэлдэхүүний тодорхойлолт, холбогдох материалыг 45, салбарын шагналын тодорхойлолт, холбогдох материалыг 30 хоногийн өмнө цахим болон хэвлэмэл /хураангуй/ хэлбэрээр яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

4.3. Шагнуулах бие бүрэлдэхүүний тодорхойлолт, холбогдох материалыг хянан боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, Монгол Улсын цол хүртээх, төрийн дээд одон медалиар шагнуулах асуудлыг 30 хоногийн өмнө холбогдох дээд байгууллагуудад уламжилна.

4.4. Шагналыг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”, холбогдох бусад эрх зүйн баримт бичигт тусгагдсан өдрүүд, энхийг сахиулах, дэмжих, бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэсний дараа тус тус олгоно.

4.5. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-д нийцүүлэн “Зэвсэгт хүчний хүндэт тэмдэг”-ийг олгох журмыг Зэвсэгт хүчний Жанжин штаб тогтооно.

4.6. “Цэргийн хүндэт медаль”, “Цэргийн гавьяаны одон”-д нэр дэвшигч нь “Дайчин алдар II”, “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-д нэр дэвшигч нь “Дайчин алдар I” медалиар тус тус шагнагдсан байна.

4.7. “Цэргийн хүндэт медаль”-аар шагнуулахаар нэр дэвшсэн эмэгтэй цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил алба хаасан, энэ журмын 4.6 дахь заалтыг хангасан байна.

4.8. Тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмадуудыг Монголын ахмадын өдрөөр шагнаж, “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгний баярыг тохиолдуулан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж болно.

4.9.Шагнал, урамшууллын тайланг жил бүрийн 6, 12 дугаар сарын 20-ны дотор яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

4.10.Шагналын мэдээллийн санг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт баяжуулан хөтөлнө.

---oOo---